



АМЧАМ МОНГОЛ

ӨСӨЛТӨД ХҮРЭХ ЗАМЫН ЗУРАГЛАЛ

2025

2024 оны 12-р сар



ОРШИЛ

АмЧам Монгол нь 2025 онд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшилд суурилсан чөлөөт эдийн засгийг дэмжих, Америкийн Нэгдсэн Улс болон Монгол Улсын хооронд харилцааг эрчимжүүлэх, гишүүн байгууллагуудын өсөлт, тэдгээрийн бизнесийг өргөжүүлэхэд чиглэсэн боломжуудыг эрэлхийлэн ажиллах болно.



ХУВИЙН ХЭВШЛИЙГ ЭРГҮҮЛЭН АНХААРЛЫН ТӨВД АВЧРАХ

АмЧамын гишүүд, бизнесүүд болон хөрөнгө оруулагчдын Монголын эдийн засгийн шинэчлэлд оруулж буй хувь нэмэр, манлайллыг тодотгон харуулах нь чухал билээ. Ингэснээр зөвхөн улс төрийн нөлөөллөөр буюу Засгийн газрын шийдвэрээр хөдөлж буйгаар дүгнэгдэх эдийн засгийн загвараас хальж, хувийн хэвшлийн эерэг дүр зургийг нийтэд түгээх боломж бүрдэнэ.

01 Макро түвшинд: Хувийн хэвшилд суурилсан, чөлөөт эдийн засгийн онцлог, давуу талыг таниулахуйц цогц бодлогын нөлөөллийн ажлыг зохион байгуулна. Төрийн өмчид суурилсан капитализм буюу эдийн засаг дахь төрийн нөлөөллийг бууруулахад эдгээр нь тодорхой үр дүнтэй байх болно.

02 Микро түвшинд: Гишүүн байгууллагуудын амжилтын туршлага, манлайлал, инновацын түүхүүдээ хуваалцах орон зай, орчин нөхцөл болон боломжуудыг бүрдүүлж өгнө.

03 Тодорхой асуудлуудаар гишүүдийн байр суурийг төлөөлөх: Гишүүн байгууллагуудын байр суурийг илэрхийлж, дуу хоолойг нэгтгэн хүргэхдээ хосолмол арга барил ашиглана. Үүнд тодорхой асуудлыг хөндөх замаар дүгнэлт, зөвлөмж өгөх, аль эсвэл үүссэн нөхцөл байдалд хариулт өгөх замаар зөвлөмж, мэдээлэл хүргүүлэх арга барилууд тус тус багтана.

МОНГОЛ УЛСАД БОЛОН ГИШҮҮН БАЙГУУЛЛАГУУДАД ХЭРЭГЦЭЭТ ЭЕРЭГ МЭДЭЭЛЛИЙГ ТҮГЭЭХ

Цахим сүлжээний сувгуудыг болон веб хуудсыг эрс шинэчилж, дараах чиглэлд мэдээлэл хуваалцах: хувийн хэвшлийн амжилтын түүхүүд, гишүүн байгууллагуудын онцгой үйл явдлууд, тухайлбал АмЧамын оны шилдэг нийгмийн хариуцлагатай компаниудыг тодруулдаг "Компанийн нийгмийн хариуцлагын шагнал гардуулах" арга хэмжээ, олон улсын санхүүжилт авсан тухай мэдээлэл, эдийн засгийн өсөлтийн таамаг, дүн шинжилгээ, олон улсын санхүүгийн байгууллагуудын статистик мэдээлэл, түүнчлэн АмЧамын цаг үеийн шинж чанартай мэдээллийг тухай бүрд нь интерактив байдлаар түгээх болно.

Ач холбогдол өндөртэй үйл ажиллагаануудын оролцоог нэмэгдүүлэх, цахим орчинд түгээж болохуйц бодлогын алхмуудыг сурталчлах замаар бодлого тодорхойлогчид болон олон нийтийн анхаарлыг татах нь зүйтэй.



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ОРЧНЫГ СЭРГЭЭХ АРГА ЗАМУУД

01 Хөрөнгө оруулалтын тухай хууль: Тус хуулийн шинэчилсэн найруулга нь олон улсын түвшинд харьцуулалт хийх боломжтой, өрсөлдөхүйц, хүчтэй, итгэл төрүүлэхүйц байхад анхаарна. Шинэчилсэн найруулга батлагдах нь олон улсад эерэг дохио болох бөгөөд Монгол Улс хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх эрмэлзэлтэйг илтгэнэ.

02 Асуудлуудыг шийдвэрлэх: Хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж буй бодит асуудлуудыг шийдвэрлэхэд төвлөрнө. Монгол Улсад бизнес эрхлэхийг улс төрчид эсвэл төрийн байгууллагууд бус, харин хувийн хэвшил манлайлах хэрэгтэй. Тэр дундаа гадаад, дотоодын хөрөнгө оруулалтад саад учруулдаг, ажлын байрны тогтвортой байдалд эрсдэл учруулдаг, бизнесийг зогсоож дампууруулах, Монгол Улс дахь үйл ажиллагаагаа бүрмөсөн хаахад хүргэдэг улс төрийн шинж чанартай шийдвэрүүдийн нөлөөллийг таниулж, бодит асуудлуудыг шийдвэрлэхэд төвлөрнө.

03 Макро асуудлуудыг шийдвэрлэх: Хөрөнгө оруулалтын орчинд сөргөөр нөлөөлж буй асуудлуудад цэг тавих шаардлага үүсэж байна. Жишээлбэл: Аудит, холбогдох бусад хяналт шалгалтууд, улс төрийн шинж чанартай хүчний байгууллага оролцуулсан шалгалтууд, шүүхээр хянан шийдвэрлэх процессын учир дутагдалтай ажиллагаа, гаалийн байгууллагатай холбогдсон асуудлууд, импортыг хязгаарласан татварын бодлого зэргийг шийдвэрлэх цаг нь болсон.

04 Төрийн оролцоо: Төрийн оролцоо, нөлөөлөл бол нэн тулгамдсан асуудал билээ. Олон талаас нь тайлбарлаж болох ч төрийн өмчлөл ихсэх нь хөрөнгө оруулагчдад сөрөг дохио болдог төдийгүй төрийн түншлэлгүйгээр бизнес эрхлэх боломжгүй гэдэг далд сөрөг утга санааг агуулдаг.

05 Эрх зүйн шинэчлэл, реформ: Хуулиудын шинэчлэлд санаачилгатай хандан, хөрөнгө оруулалт болон бизнесийг дэмжсэн уялдаа холбоотой эрх зүйн орчныг бий болгоход чиглэн ажиллана. Онцлох нөлөөтэй хуулиудыг эргэн харж, хянах шаардлагатай. Үүнд Банкны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг багтана.

06 Төрийн дэмжлэг: Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд бус хувийн хэвшилд оруулах хөрөнгө оруулалтыг төр бодитоор дэмжих нь зүйтэй. Өөрөөр хэлбэл төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгохыг зогсоох юм. Тухайлбал төмөр зам, эрчим хүч, хил гаальтай холбогдох асуудлуудыг шударгаар зохицуулахыг уриалж байна.

07 Салбар тус бүрийн үнэлгээ: Монгол Улсад бизнес эрхлэхэд салбар тус бүрээр хийгдсэн үнэн бодит үнэлгээ хэрэгцээтэй байна. Жишээлбэл банкны салбарт, франчайзинг бизнест, ашигт малтмалын салбарт бизнес эрхлэх нөхцөл байдлын үнэлгээг хийж, нээлттэй танилцуулах шаардлагатай.

АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСТАЙ ГУРАВДАГЧ ХӨРШИЙН БОДЛОГЫН ДАГУУ УЯЛДАА ХОЛБООГ ХАНГАН АЖИЛЛАХ

01 Хоёр талын эдийн засаг, худалдааны харилцааг өргөжүүлэхийн тулд стратегийн түвшинд хэрэгцээ шаардлагуудыг нэгтгэн, бодит нөхцөл байдлыг бэрхшээлүүдийн хамт бүрэн ойлгож, цаашдын алхмуудыг тодорхойлно.

02 Америкийн Нэгдсэн Улсаас стратегийн түвшинд тодорхойлсон салбаруудад ахиц дэвшил гаргахыг дэмжиж ажиллана. Тухайлбал эрчим хүчний шилжилт, газрын ховор элемент, шууд нислэг зэрэг онцлох санаачилгуудад анхаарна.

03 Ил тод байдлын гэрээний хэрэгжилтийг бүрэн хангахаар ажиллана. Америк Монголын хоёр талын харилцааг хөгжүүлэх "Doorknock" хэмээх өндөр хэмжээний ач холбогдолтой уулзалтуудыг Америкийн Нэгдсэн Улсад болон Монгол Улсад тус тус зохион байгуулна. Түүнчлэн хоёр талын харилцааг хөгжүүлэх хүрээнд Конгрессын төлөөлөгчдийг хүлээж авах, Конгрессын Найрамдлын бүлэгтэй хамтран ажиллах, Худалдааны яамны итгэмжлэгдсэн бизнес аялал зохион байгуулах болон бусад санаачилгууд багтана.

04 Хоёр талын Засгийн газартай маш тодорхой хамтын ажиллагааг үүсгэж, бэхжүүлнэ.

Эдгээр өндөр ач холбогдолтой хөгжлийн зорилтуудад хүрэхийн тулд үр дүн, хугацааны хувьд нарийвчилсан ажлын төлөвлөгөө бэлтгэгдэн гарах болно. Ингэснээр явцыг хянах, үр дүнг тухай бүрд нь тодорхойлох боломж бүрдэх юм.

